



ХӨГЖЛИЙН

М.ОДГЭРЭЛ

БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АНАГААХ УХААН
СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН БРӨНЖИЙ МЭРГЭЖИЛТЭН

Л.УНДРАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ
“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД СУДЛАЛ”
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын хугацаа: 3 сар

Улаанбаатар хот

2025 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Д.Даваалхам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, профессор

М.Ундрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний газрын дарга, Анагаах ухааны доктор

С.Эвлэгсүрэн, Азийн хөгжлийн банкны “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох нь” техник тусалцааны төслийн дотоодын зөвлөх

Ц.Энх-Оюун, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эпидемиологи, биостатистикийн тэнхим, Анагаах ухааны доктор, дэд профессор

А.Энхжаргал, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Орчны эрүүл мэндийн албаны эрдэм шинжилгээний ажилтан, Анагаах ухааны доктор

Д.Оюунгэрэл, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын албаны томуугийн нэгжийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр

С.Амарзаяа, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын албаны халдварын хяналтын тасгийн дарга

Н.Алтанзул, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга, Анагаах ухааны доктор

Э.Пүрэвсүрэн, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын албаны дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр

Б.Баярмаа, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн ахлах зэрэг

М.Хишгээ, “Эрүүл мэндийн форум” төрийн бус байгууллагын захирал, Нийгмийн эрүүл мэндийн магистр

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Б.Ганбат, ЭМЯ, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн Өрийг эрүүл мэндэд хөрвүүлэх хөтөлбөрийн мэргэжилтэн, Анагаах ухааны доктор

Ш.Солонго, ЭМХТ-ийн гадаад харилцаа, төсөл хөтөлбөрийн мэргэжилтэн, Нийгмийн эрүүл мэндийн магистр

ХЯНАСАН:

Д.Дондогмаа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга

Ц.Даваахүү, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны мэргэжилтэн

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ “НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД СУДЛАЛ”
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцооны суурь тулгуур бөгөөд иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, шаардлагатай тусламж үйлчилгээ авах үндсэн эрхээ эдлэх боломжийг хангах гол түвшин юм. Эрүүл мэндийн тухай хуулийн 1.1-д энэхүү зорилтыг тодорхойлж, 13.2-д нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үндсэн чиг үүргийг агуулна гэж заасан.

Мөн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 1.1-д хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээ авах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг төрөөс зохион байгуулж, санхүүжүүлж, хянаж байх үүргийг хуульчилсан. Иймээс өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн нь энэхүү чиг үүргийг анхан шатанд хэрэгжүүлэгч гол ажилтан юм.

ДЭМБ-ын 2024 онд шинэчлэн гаргасан “Нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргүүд” баримт бичигт нийгмийн эрүүл мэндийг өвчний гол шалтгааныг илрүүлж, олон нийтийн эрүүл мэндийг сайжруулах өргөн хүрээний бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоот хандлага хэмээн тодорхойлсон. Нийгмийн эрүүл мэндийн хандлага сул үед эрүүл мэндийн үйлчилгээ хэсэгчилсэн, жигд бус, тэгш бус байдлаар хүрч, эрүүл мэндийн ялгаа гүнзгийрдэг. Нийгмийн эрүүл мэндийн бодлого, арга хэмжээ нь хүн амын бүлэг бүрийн хэрэгцээг таньж, тэгш боломжийг бүрдүүлж, эрүүл мэндийн ялгааг багасгахад чиглэх ёстой. Ийм зарчмыг хангахын тулд өвчилсний дараах тусламж үйлчилгээнээс илүүтэйгээр эрт илрүүлэг, өвчин үүсэхээс сэргийлэх, эрүүл орчин бүрдүүлэх, мэдээлэл таниулга, зан үйлийг дэмжих ажилд анхаарах нь үр ашигтай, тогтвортой шийдэл болохыг олон улсын судалгаанууд харуулж байна.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны ач холбогдол хэдийгээр тодорхой ч Монгол улсад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний түвшинд тандалт, мэдээллийн чанар тогтмол жигд бус, эрт илрүүлэг хангалтгүй, зан үйлийн сургалт,

олон нийттэй харилцах ур чадвар дутмаг, олон салбарын хамтын ажиллагаа сул, чанарын тогтолцоо, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт сул, эрүүл мэндийн онцгой байдал, гамшгийн бэлэн байдал дутуу, эм, хэрэгслийн нөөцийн удирдлага алдагдалтай зэрэг бодит хүндрэл тулгарсаар байна.

Нөгөө талаас Монгол Улсад халдварт болон халдварт бус өвчлөл нэмэгдэх, уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол, хооллолтын зохисгүй дадал, тамхи, согтууруулах ундааны хэт хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний эрсдэл өсөх зэрэг эрүүл мэндийн асуудлууд хурцаар тавигдаж байна. Эдгээр эрсдэл нь өрх, сумын түвшинд ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдэд илүү нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ахисан түвшний мэдлэг, чадамжийг шаардаж байна.

ДЭМБ-аас тодорхойлсон Нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүрэг (EPHF – Essential Public Health Functions) нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтолцооны бүх түвшинд жигд, чанартай хэрэгжүүлэх олон улсын суурь стандарт юм. Эдгээр чиг үүргийг бодитой хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай 6 бүлэг чадамж, эдгээрийг илэрхийлэх 20 мэргэжлийн чадвар, тэдгээр дээр суурилсан 40 үндсэн үйл ажиллагаа нь анхан шатны тусламжийн түвшинд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн өсөлт, хөгжлийг дэмжих дэлхийн нийтлэг жишиг шаардлага болж байна.

Монгол улсад өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүд нь хүн амд хамгийн ойр байрлаж, өвчний тандалт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийг дэмжих, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, орчны эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед шуурхай хариу арга хэмжээ авах зэрэг олон чиг үүргийг өдөр тутам гүйцэтгэдэг. Гэхдээ хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үүрэг хариуцлага, хүн амын эрүүл мэндийн өнөөгийн байдал, эмзэг бүлгийн хэрэгцээ, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхын ялгааг харгалзан үзвэл эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамжийг шат дараатай олгох сургалтын хэрэгцээ маш өндөр байна.

Иймээс нийгмийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах сургалтын цөм хөтөлбөрын агуулга, цогц чадамжид тулгуурлан, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын бодит нөхцөл байдалтай уялдсан, анхан шатны эрүүл мэндийн ажилтны нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн өсөлт, дэвшлийг дэмжих мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг

боловсруулан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Энэ сургалт нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний түвшинд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийг сайжруулах ач холбогдолтой.

Сургалтын хөтөлбөр боловсруулсан аргачлал:

Энэхүү хөтөлбөрийг ДЭМБ-ын "Нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргүүд" (EPHF), чадавхид суурилсан сургалтын олон улсын зарчим, Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн хүний нөөцийн бодит хэрэгцээ, орон нутгийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, орчны нөхцөлд тулгуурлан боловсрууллаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн үндсэн чиг үүргүүд:

Нийгмийн эрүүл мэндийн гол зорилго нь өвчин, гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг дэмжих, өвчнөөс ангид орчин бүрдүүлэхэд оршдог. Үүний тулд өвчин, эмгэгийн суурь шалтгаануудыг илрүүлэн шийдвэрлэх, эрүүл мэндэд нөлөөлдөг өргөн хүрээний нийгмийн, эдийн засгийн, байгаль орчны хүчин зүйлсийг тогтоож, хүн амын түвшний системтэй бодлогын шийдлүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол улсын хувьд халдварт өвчин, халдварт бус өвчин, агаарын бохирдол, хүн амын тархай байрлалт, хот-хөдөөгийн тэгш бус байдал, нийгмийн эрүүл мэндийн зохистой дадал хэвшил төлөвшөөгүй зэрэг олон хүчин зүйлс эрүүл мэндийн тогтолцоонд нөлөөлж ирсэн нь нийгмийн эрүүл мэндийн хандлагын ач холбогдлыг улам бүр тодотгож байна.

Нийгмийн эрүүл мэндийн хандлага хангалтгүй, салбар хоорондын уялдаа сул, урьдчилан сэргийлэх бодлого системтэй хэрэгжээгүй бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэсэгчилсэн, тэгш бус, хүртээмж багатай болж, эмчлэх үйлчилгээ давамгайлсан, өндөр зардалтай, үр ашиг багатай тогтолцоо бүрэлддэг. Монгол улсад хот, хөдөөгийн ялгаа, хүн амын орлогын түвшнээс хамаарсан үйлчилгээний тэгш бус байдал, халдварт бус өвчний эрт илрүүлгийн чанар, хамралт багассан зэрэг асуудлууд үүнийг нотлон харуулж байна. Тиймээс иж бүрэн, нотолгоонд тулгуурласан, нийгмийн бүх бүлгийг хамарсан нийгмийн эрүүл мэндийн нэгдмэл хандлага нь Монгол улсад Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, чанартай, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээг бодит ажил болгох, онцгой байдлын эрсдэлээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндсэн нөхцөл юм.

Хүн амын эрүүл мэндийн тэгш байдлыг хангах нь нийгмийн эрүүл мэндийн бодлогын цөм:

Нийгмийн эрүүл мэндийн үр дүнтэй үйл ажиллагааны хамгийн гол суурь нь хүн бүрийн, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг хамгаалах хариуцлага юм.

Монгол улсад өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядуу өрх, хөдөө орон нутгийн хүн ам, залуучууд (бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн хувьд) зэрэг бүлгүүд эрүүл мэндийн тэгш бус байдлыг илүү ихээр мэдэрдэг.

Эрүүл мэнд бол үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх. Эрүүл мэндийн тэгш байдал гэдэг нь хүн бүр орлого, амьдралын нөхцөл, газар зүйн байршлаас үл хамааран эрүүл мэндээ хамгаалах үйлчилгээ, нөөц боломжид ижил тэгш хүртээмжтэй байхыг илэрхийлнэ. Иймээс нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа нь шударга ёс, хүний эрх, тэгш боломжийн зарчимд тулгуурлан, хүн амын ялгаатай байдлыг багасгаж, хүн бүрийг хамгийн өндөр түвшний эрүүл мэнд, сайн сайхан байдалд хүргэхэд чиглэвэл зохино.

Урьдчилан сэргийлэх ба хамгаалах бодлого нь эрүүл мэндийн тогтолцооны тогтвортой байдлын үндэс:

Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ нь өвчин гарсны дараа эмчлэх арга хэмжээнээс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх, хамгаалах, эрүүл мэндийг дэмжих зарчимд тулгуурладаг. Монгол улсын хувьд өндөр тархалттай болсон артерийн даралт ихсэлт, чихрийн шижин, хавдар, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг эрс сайжруулах шаардлагатайг харуулдаг. Урьдчилан сэргийлэх бодлого, хүн ам төвтэй арга хэмжээ нь:

- Эрүүл мэндийн тогтолцоонд учрах дарамтыг бууруулдаг
- Өндөр зардалтай эмчилгээний хэрэгцээг багасгадаг
- Хүний амьдралын чанарыг сайжруулдаг
- Урт хугацаандаа төсөвт өртөг хэмнэдэг гэх мэт олон талын өгөөжтэй.

Гэвч Монгол Улсад ч гэсэн өвчин гарсны дараа хариу үзүүлэх хандлага давамгайлах, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ хангалттай санхүүждэггүй, салбар хоорондын хариуцлага тодорхойгүй зэрэг асуудал тулгарч байна. Иймээс нийгмийн эрүүл мэндийн бодлого зөвхөн эрүүл мэндийн салбарын ажил биш бөгөөд боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, зам тээвэр, хүрээлэн буй орчин, хүнс зэрэг бүхий л салбарын бодлого эрүүл мэндэд эерэг нөлөөтэй байх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд КОВИД-19 цар тахал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй утаа, тоосжилт, байгалийн гамшгийн давтамж, халдварт болон халдварт бус өвчний өсөлт, хүн амын насжилт, хавсарсан олон архаг өвчлөл, бичил биетний тэсвэржилтийн асуудал зэрэг олон сорилт Монгол Улсад нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг бүрэн хүчээр хэрэгжүүлэх шаардлагыг тодорхой харуулсаар байна.

КОВИД-19 цар тахал Монгол улсад тандалт, хариу арга хэмжээний тогтолцооны чадавх хангалтгүй, эрүүл мэндийн мэдээллийн уялдаа сул, эрүүл мэндийн ажиллах хүчний ачаалал өндөр, эм, оношлуур, хүчилтөрөгчийн хангамж тасалдах эрсдэлтэй зэрэг олон асуудал байгааг илрүүлсэн нь нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг иж бүрэн хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ байгааг нотолсон.

ДЭМБ-аас тодорхойлсон Нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүрэг нь улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны дархлааг бэхжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтыг хэрэгжүүлэх, онцгой байдлын эрсдэлийг бууруулах, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нэгдсэн загвар юм. Монгол улс эдгээр чиг үүргийг хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, эрсдэлийн бүтэц, нутаг дэвсгэрийн онцлог, нөөц, боломж, бодлогын тэргүүлэх чиглэл зэрэгтэй уялдуулан хэрэгжүүлэх замаар эрүүл мэндийг хамгаалах чадавх бэхжиж, тогтолцооны нэгдмэл байдал, хүртээмж, үр ашиг нэмэгдэнэ.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амын эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэрээ оруулахын тулд нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг орон нутгийн түвшинд нотолгоонд түшиглэн үр дүнтэй хэрэгжүүлэх чадвар, олон нийтэд чиглэсэн, тэгш байдлыг эрхэмлэх хандлага эзэмших.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

“Нийгмийн эрүүл мэнд судлал” мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилтны дүр зураг:

“Нийгмийн эрүүл мэнд судлал” мэргэжил дээшлүүлэх сургалтыг төгсөгч нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь мэдлэг, ур чадвар, хандлага, мэргэжлийн зан үйлийг бүрэн эзэмшсэн, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог орон нутгийн түвшинд бэхжүүлэх чадавхтай бие даасан бөгөөд хариуцлагатай эрүүл мэндийн ажилтан байна.

ДӨРӨВ. СУРГАЛТААР ЭЗЭМШИХ ЧАДАМЖ

Монгол улсын эрүүл мэндийн мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 6 бүлэг яадамжийг эзэмшсэн байна. Үүнд:

1. Олон нийтийн оролцоог дэмжиж, тэгш байдал ба оролцоог эрхэмлэдэг.
2. Өдөр тутмын ажилд болон хамтын шийдвэр гаргалтад ёс зүй, нийгмийн эрүүл мэндийн үнэт зүйлсийг эрхэмлэдэг.
3. Хувь хүн, олон нийт, түнш байгууллагуудтай үр дүнтэй харилцдаг.
4. Баг, олон нийтийн бүлэг, салбар хоорондын хамтын ажиллагааг удирдан зохицуулдаг.
5. Мэдээлэл, нотолгоог үнэлж ашиглан, чанарын сайжруулалт хийдэг.
6. Мэргэжлийн ёс зүй, хувь хүний хөгжил, эрүүл мэндийг хамгаалдаг.

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

1. Нийгэм—олон нийтийн төвтэй хандлага (Холбогдох Чадамж-1, РА: 2, 23, 24, 27, 28)

- Олон нийтийн эрүүл мэндийн хэрэгцээ, эмзэг байдал, эрсдэлийг үнэлэх суурь чадвар эзэмших.
- Хороо, баг, сургууль, цэцэрлэг зэрэг орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх арга зүйд суралцах.
- Эрүүл мэндийн тэгш байдлыг хангах, эмзэг бүлгүүдийг эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэлд хүртээмжтэй болгох чадамж төлөвшүүлэх.

2. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт (Холбогдох Чадамж- 2, РА: 12–21)

- Анхан шатны тандалтын мэдээллийг цуглуулах, нэгтгэх, энгийн анализ хийх чадварт суралцах.
- Эрсдэлийн мэдээллийг үндэслэн шийдвэр гаргах, дээд шатанд мэдээлэх, тэгш шударга сонголт хийх арга барил эзэмших.
- Эрүүл мэндийн гэнэтийн аюул илэрсэн үед хурдан дасан зохицох, төлөвлөгөө боловсруулах чадвар эзэмших.

3. Харилцаа ба эрсдэлийн үеийн мэдээлэл түгээх (Холбогдох чадамж -3, РА: 20, 21, 26, 27, 28)

- Иргэдэд ойлгомжтой, соёлд нийцсэн, энгийн хэлээр эрүүл мэндийн мэдээлэл дамжуулах чадварыг сайжруулах.

- Эрсдэлийн үед олон нийттэй харилцах суурь арга зүйд суралцах.
- Олон нийтийн итгэлийг хадгалах, зөв мэдээлэл түгээх, буруу мэдээллийг хянах чадвар эзэмших.

4. Хамтын ажиллагаа ба салбар хоорондын зохицуулалт (Холбогдох чадамж- 4, РА: 23–25, 31–35)

- Орон нутгийн түвшинд эрүүл мэндэд нөлөөлдөг гол салбаруудтай (боловсрол, байгаль орчин, хүнс, хөдөлмөр) уялдуулан ажиллах чадвар эзэмших.
- Сум/хорооны эрүүл мэндийн баг, аймаг/дүүргийн НЭМ мэргэжилтэн, НҮТББ-тай хамтран ажиллах чадамжийг бүрдүүлэх.
- Зөрчил, санал зөрөлдөөн, эсэргүүцлийг бүтээлч аргаар зохицуулах чадвар хөгжүүлэх.

5. Нотолгоонд суурилсан НЭМ практик (Холбогдох чадамж-5, РА: 12–30)

- Халдварт ба халдварт бус өвчний эрт илрүүлэлт, зан үйлийн эрсдэлийн үнэлгээг стандартын дагуу гүйцэтгэх.
- Түргэвчилсэн үнэлгээ (rapid assessment), олон нийтийн шинж байдлыг үнэлэх суурь ойлголт эзэмших.
- НЭМ хөтөлбөрийн үр дүнг хянах, тайлагнах, сайжруулалтын санаа гаргах чадвартай болох.

6. Ёс зүй, хувийн хариуцлага, мэргэжлийн хөгжлийн зан үйл (Холбогдох чадамж – 6, РА: бүх үйл ажиллагааны суурь)

- Мэргэжлийн ёс зүй, хүний эрх, соёлын мэдрэмжийг баримталж ажиллах зан үйлийг төлөвшүүлэх.
- Өөрийн гүйцэтгэлийг үнэлэх, тасралтгүй суралцах, стресс менежмент хийх чадвар эзэмших.
- Хариуцлагатай, хүртээмжтэй, оролцоог дэмжсэн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх арга барил төлөвшүүлэх.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сургалт дүүргэсэн эрүүл мэндийн ажилтан дараах суурь чадамжийг эзэмшинэ:

1. Тандалт, эрт илрүүлэлт, тайлагналын үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэх
2. Дэгдэлтийн үед анхан шатны хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх
3. ХБӨ-ийн эрсдэлт хүчин зүйлсийг үнэлж, зөвлөгөө өгөх
4. Өрх, багийн түвшинд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх
5. Олон нийтийн эрүүл ахуйн эрсдэлийг тодорхойлж зөвлөмж өгөх
6. Олон нийтийг оролцуулах, хамтын ажиллагааг удирдах
7. Чанартай, ёс зүйтэй, тэгш байдалд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх

ДОЛОО. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтын чиглэл, сургалт явагдах газар:

Сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эрүүл мэндийн ажилтанд зориулсан “Нийгмийн эрүүл мэнд судлал” сургалт эрхлэх зөвшөөрөл авсан байгууллага энэхүү сургалтыг явуулна.

Зорилтот бүлэг

Энэ хөтөлбөр нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагад ажиллаж буй эмч, сувилагч, нийгмийн ажилтан болон бусад эрүүл мэндийн ажилтны нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх суурь чадамжийг нэмэгдүүлэх, тогтолцооны түвшний үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бэлэн байдлыг дээшлүүлэх зорилготой мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр юм.

Сургалтын гол чиглэл нь ДЭМБ-ын тодорхойлсон нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүрэг (EPHF)-ийг Монгол Улсын хууль эрх зүй, үндэсний хөтөлбөрүүд, анхан шатны тусламж үйлчилгээний бодит хэрэгцээтэй уялдуулан чадавхжуулахад чиглэнэ. Хөтөлбөр нь нийгмийн эрүүл мэндийн тандалт, эрсдэлийн үнэлгээ, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, олон нийтийн оролцоо, мэдээллийн системийн ашиглалт, зан үйлийн зөвлөгөө, орчны ба хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, эм-вакцины зохистой хэрэглээ зэрэг өргөн хүрээний чадамжийг хамрана.

Сургалтын нийт хугацаа 3 сар /12 долоо хоног/ явагдах бөгөөд долоо хоногт 40 академик цаг (1 академик цаг = 45 минут)-аар тооцно. Хичээл нь танхимын сургалт, цахим хэлбэр, ажлын байрны дадлага сургалт, семинар, багийн ажил, вебинар, бие

даалтын ажил зэргийг уялдуулсан хосолмол сургалтын загвараар зохион байгуулагдана.

Сургалтын турш:

- I–XI долоо хоногт модуль сургалт,
- XII долоо хоногт төгсгөлийн шалгалт, портфолио хамгаалалт хийгдэнэ.

Байршил: Сургалтын хөтөлбөрийг төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага, их дээд сургуулийн нийгмийн эрүүл мэндийн тэнхим, үндэсний лавлагаа шатлалын төвийг түшиглэн хэрэгжүүлнэ.

Суралцагчийн ажлын байрны нөхцөлд нийцүүлэх үүднээс:

- Онлайн хэлбэрийн лекц, вебинар — алслагдсан аймаг, сумдад хүртээмжтэй байхаар,
- Орон нутгийн эрүүл мэндийн төвүүд дээрх дадлага сургалт — өдөр тутмын үйл ажиллагааны бодит орчинд,
- Үндэсний төв байгууллагад хийх богино хэмжээний суурин дадлага — тандалт, лабораторийн чанарын хяналт, эрсдэлийн харилцаа зэрэг чиглэлээр явуулна.

Сургалтын төлөвлөгөө, агуулга

Энэхүү 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулга нь ДЭМБ-ын тодорхойлсон нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүрэг, Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн хууль эрх зүйн зохицуулалт, анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагын бодит хэрэгцээ, цөм хөтөлбөрийн 12 цөм агуулгад тулгуурлан боловсруулагдсан. Агуулга нь эрүүл мэндийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа, хүн амын эрүүл мэндийн эрсдэлийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн түвшний эрүүл мэндийг дэмжих, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжихэд чиглэнэ.

Сургалтын төлөвлөгөө нь 12 долоо хоногийн модуль бүтэцтэй бөгөөд модуль бүр нь тодорхой чадамжийг эзэмшүүлэх зорилготой логик дараалал, онол, практикийн хосолсон аргачлалтай. Сургалтын үйл явц нь лекц, семинар, кейс судалгаа, ажлын байрны орчинд дадлага, вебинар, багийн ажил, бие даалтын бодит даалгавар зэргийг хослуулсан хосолмол сургалтын загвараар зохион байгуулагдана.

Модуль бүрийн төгсгөлд богино хэлбэрийн явцын үнэлгээ, сургалтын төгсгөлд мэдлэг, чадварын нэгдсэн шалгалт болон портфолио хамгаалалт хийгдэнэ. Ингэснээр суралцагч нь эзэмшсэн мэдлэг, ур чадвараа ажлын байран дээр бодитоор хэрэгжүүлж чаддаг эсэхийг баталгаажуулна.

Сургалтын үндсэн агуулга дараах 12 цөм агуулгын хүрээнд төлөвлөгдсөн модуль бүтэцтэй:

1. НЭМ-ийн үндсэн чиг үүрэг ба Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо
2. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт ба тандалт
3. Эрсдэлийн үнэлгээ, бэлэн байдал, хариу арга хэмжээ
4. Эрүүл мэндийг дэмжих, зан үйлийн өөрчлөлтийн шинжлэх ухаан
5. Олон нийтийн оролцоо ба хамтын ажиллагаа (RCCE)
6. Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, засаглал, бодлого төлөвлөлт
7. Салбар хоорондын хамтын ажиллагаа ба эрүүл мэндийн нөлөөллийн шийдвэр
8. Нийгмийн эрүүл мэндийн санхүүжилт ба нөөцийн оновчтой удирдлага
9. Эрүүл мэндийн мэдээллийн систем ба дүн шинжилгээ
10. Эрүүл мэндийг хамгаалах: орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал
11. Судалгаа, нотолгоо, мэдлэгийн удирдлага
12. Эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, технологийн хүртээмж ба зохимтой хэрэглээ

Сургалтын агуулга нь анхан шатны эрүүл мэндийн ажилтныг:

- нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг таньж үнэлэх,
- өвчин, гэмтлийн тандалт–тайлагналт хийх,
- олон нийтийн оролцоог идэвхжүүлэх,
- эрүүл мэндийн зан үйлийн зөвлөгөө өгөх,
- эрүүл мэндийг дэмжих, хамгаалах,
- мэдээллийн систем ашиглан дүн шинжилгээ хийх,
- нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд шийдвэр гаргах чадвартай бие даасан мэргэжилтэн болгож хөгжүүлэхэд чиглэнэ.

Хөтөлбөрийн төгсгөлд суралцагч нь үндсэн чиг үүргийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх суурь мэдлэг, чадамжтай болж, бодит асуудлыг илрүүлэн шийдвэрлэхэд нотолгоонд тулгуурласан арга зүй ашиглах ур чадвартай болно.

Сургалтын төлөвлөгөө

Долоо хоног	Хамрагдах модуль	Товч агуулга / Онцлог	Үнэлгээ
1-р долоо хоног	Хөтөлбөрийн танилцуулга Модуль 1	НЭМ-ийн 12 чиг үүрэг, Монгол улсын НЭМ-ийн тогтолцоо, хууль эрх зүй, анхан шатны байгууллагын үүрэг	Сургалтын өмнөх үнэлгээ
2-р долоо хоног	Модуль 2 (I хэсэг)	Тандалтын үндэс, мэдээлэл цуглуулах, ажиглалт-тайлагналын суурь арга	—
3-р долоо хоног	Модуль 2 (II хэсэг)	Өгөгдөл боловсруулах, хандах, дүн шинжилгээ; эрт сэрэмжлүүлэх дохио илрүүлэх	Явцын үнэлгээ 1
4-р долоо хоног	Модуль 3	Эрсдэлийн үнэлгээ, гамшиг/онцгой байдлын үндсэн зарчим, халдварын сэргийлэлт хяналт, орон нутгийн бэлэн байдал	—
5-р долоо хоног	Модуль 4	Зан үйлийн өөрчлөлтийн онол, зан үйлийн загварууд (HBM, COM-B, Transtheoretical model) Зөвлөгөө өгөх арга барил, эрүүл мэндийг дэмжих кампанит ажил; олон нийтийн оролцооны үндэс	—
6-р долоо хоног	Модуль 5	Олон нийтийн оролцоо ба нийгмийн хамтын ажиллагаа	Явцын үнэлгээ 2
7-р долоо хоног	Модуль 7	НЭМ удирдлага, бодлого-төлөвлөлт, оролцогч талуудын шинжлэгээ, бодлогын нөлөөлөл	—
8-р долоо хоног	Модуль 6 Модуль 8	Санхүүжилтийн суурь ойлголт, өртгийн тооцоо, анхан шатны байгууллагын нөөцийн оновчтой хуваарилалт	Явцын үнэлгээ 3
9-р долоо хоног	Модуль 9	Эрүүл мэндийн мэдээллийн систем, мэдээлэл ашиглах чадвар (data literacy), шийдвэр гаргалтад мэдээлэл ашиглах	—
10-р долоо хоног	Модуль 10 Модуль 12	Орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал; эм, вакцин, тоног төхөөрөмжийн зохистой хэрэглээ	Явцын үнэлгээ 4

Долоо хоног	Хамрагдах модуль	Товч агуулга / Онцлог	Үнэлгээ
11-р долоо хоног	Модул 11	Судалгаа, нотолгоо, мэдлэгийн удирдлага; богино төсөл	
12-р долоо хоног	Төгсгөлийн шалгалт	портфолио	Төгсгөлийн шалгалт + Портфолио

НАЙМ. СУРГАЛТЫН АГУУЛГА

1 дүгээр долоо хоног: Модуль 1. Нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиг үүрэг ба Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо

Модулийн зорилго:

Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн түвшинд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтан нь Нийгмийн эрүүл мэндийн 12 үндсэн чиг үүргийг ойлгон хэрэглэж, Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн тогтолцоонд эзлэх өөрийн хариуцлага, гүйцэтгэх үйл ажиллагаа, оролцооны түвшинг тодорхойлох чадамжтай болох.

Модулийн үндсэн агуулга

Нийгмийн эрүүл мэндийн үзэл баримтлал ба үндсэн зарчим

- Нийгмийн эрүүл мэндийн зорилго, хөгжлийн түүх
- Эрүүл мэнд ба өвчний таларх өргөн хүрээний ойлголт (нийгмийн, эдийн засгийн, зан үйлийн, орчны хүчин зүйл)
- Эрүүл мэндийн тэгш байдал, хүний эрх, оролцооны зарчим

ДЭМБ-ын тодорхойлсон 12 үндсэн чиг үүрэг

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чиг үүргийг НЭМ-ийн үндсэн үүрэг, 40 практик үйл ажиллагаатай уялдуулах

Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо

- НЭМ-н тусламж үйлчилгээний тогтолцооны бүтэц, зохион байгуулалт
- НЭМ-ийн хууль эрх зүй:

Суралцахуйн үр дүн

Модуль 1-ийг судалснаар суралцагч дараах чадамжийг эзэмшинэ:

- 12 чиг үүргийг нэрлэж, зорилго болон хоорондын уялдааг тайлбарлах
- Монгол Улсын НЭМ тогтолцооны бүтэц, эрх зүйн зохицуулалт, үүргийн хуваарийг тодорхойлох

- ӨЭМТ, СЭМТ, сум/хорооны түвшинд НЭМ чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэхийг бодитоор тайлбарлах
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээн дэх эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэх чиг үүргийн хүрээг өөрийн ажлын байрны үүрэгтэй уялдуулах
- 12 үндсэн чиг үүрэг болон 40 практик үйл ажиллагааны (Practice Activities) уялдааг таньж, өөрийн оролцох үйл ажиллагааг тодорхойлох
- Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн өнөөгийн тулгамдсан асуудлыг үндсэн чиг үүргийн хүрээнд ангилан тайлбарлах
- Өөрийн байгууллагын (ӨЭМТ/СЭМТ) НЭМ чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 8 академик цаг

1. Нийгмийн эрүүл мэндийн үндсэн ойлголт, зарчим

- Эрүүл мэндийн өргөн хүрээний тодорхойлолт болон нийгмийн тодорхойлогч хүчин зүйлс
- Эрүүл мэндийн тэгш байдал, хүний эрх ба оролцооны зарчим
- Эрүүл мэндийн салбарын болон салбар хоорондын хамтын ажиллагааны ач холбогдол

2. ДЭМБ-ын тодорхойлсон НЭМ-ийн 12 үндсэн чиг үүрэг (EPHF)

- Чиг үүрэг бүрийн зорилго, утга агуулга
- Анхан шатанд эдгээр чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах гол үйл ажиллагаа
- НЭМ-ийн тусламж үйлчилгээний үндсэн чиг үүрэг → 6 чадамж → 20 чадвар → 40 үйл ажиллагааны уялдаа

3. Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо ба хууль эрх зүй

- Орон нутгийн түвшний НЭМ-ийн оролцоо, хариуцлага, хэрэгжүүлэх арга зам

Семинар — 4 академик цаг

1. НЭМ-ийн 12 үндсэн чиг үүрэг –Анхан шатны ажилтны үүргийн уялдаа

- Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн түвшинд аль нийгмийн эрүүл мэндийн аль чиг үүргийг хэрэгжүүлдэг вэ?
- 40 үйл ажиллагаанаас ӨЭМТ/СЭМТ-ийн өдөр тутмын ажилд хамаарах нь
- Жишээ тохиолдлын анализ

2. НЭМ чиг үүрэг ба ӨЭМТ/СЭМТ-ийн үйл ажиллагаа

- Суралцагч бүр өөрийн байгууллагын нөхцөл байдлын жишээ авч хэлэлцэнэ

- Орон нутгийн хэрэгцээнд нийцсэн НЭМ-ийн бодит гүйцэтгэл, сул тал, боломжийг тодорхойлох

Дадлага — 4 академик цаг

ӨЭМТ/СЭМТ түвшинд НЭМ чиг үүргийн хэрэгжилтийн SWOT шинжилгээ

- Хүчтэй тал — Гүйцэтгэл сайтай чиглэлүүд
- Сул тал — Чадамж, нөөц, мэдээлэл, дэд бүтцийн дутагдал
- Боломж — Орчны болон салбар хоорондын давуу тал
- Саад бэрхшээл — Нөөцийн хязгаар, удирдлагын сул тал, хүн хүч

→ Бүлгээр эсвэл ганцаарчилсан байдлаар гүйцэтгэж, дараагийн долоо хоногт танилцуулна.

Бие даалт — 2 академик цаг

НЭМ-ийн 12 үндсэн чиг үүрэг –Орон нутгийн бодит нөхцөл байдалд нийцүүлэх эргэцүүлэх дадлага

Суралцагч дараах асуултад төвлөрөн богино эргэцүүлсэн тайлан бичнэ:

- Миний байгууллага EPHF-ийн аль чиг үүргийг сайн хэрэгжүүлж байна вэ?
- Аль чиглэлд чадамж дутагдаж байна?
- Ямар орчны нөхцөл, бодит саад бэрхшээл байна вэ?
- Миний гүйцэтгэх үүрэг НЭМ-ийн 12 үндсэн чиг үүрэгтэй хэрхэн нийцэж байна вэ?

Үнэлгээ — 1 академик цаг

Сургалтын эхлэлийн үнэлгээ (Pre-test)

30–40 асуулт бүхий сорил

Суралцагчийн одоогийн мэдлэг, ойлголтын түвшнийг тодорхойлно

2, 3 дугаар долоо хоног: модуль 2. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт ба нийгмийн эрүүл мэндийн тандалт

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн тандалтын үндсэн ур чадварыг эзэмшүүлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, эрүүл мэндийн эрсдэл, хэвийн бус үзүүлэлт, өвчний дэгдэлтийн эрт сэрэмжлүүлгийг илрүүлэх чадварыг дээшлүүлэхэд оршино.

Энэ модуль нь НЭМ-ийн тусламж үйлчилгээний Тандалт, хяналт, Эрүүл мэндийн аюулын эрт илрүүлэлт, Нотолгоо ба судалгаа, Үйлчилгээний чанар ба тэгш байдал

зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах суурь чадамжуудыг боловсронгуй болгоно.

Модулийн үндсэн агуулга

Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт

- Нотолгооны шатлал ба төрлүүд
- Анхан шатны түвшинд нотолгоо ашиглах гол зарчим
- Мэдээлэл–шийдвэрийн уялдаа, түгээмэл алдаа
- Монгол улсын НЭМ-ийн шийдвэр гаргалт: мэдээллийн урсгал, үүрэг хариуцлага

Нийгмийн эрүүл мэндийн тандалт (Surveillance)

- Тандалтын зорилго, чиглэл, төрөл
- Тандалтын үндсэн бүртгэл: бүртгэлийн маягтууд, тохиолдлын тодорхойлолт
- Мэдээлэл цуглуулах арга, орон нутгийн нөхцөлд үүсдэг нийтлэг алдаа
- Тандалтын чанарын шалгуур (Completeness, Timeliness, Accuracy)

Эрт сэрэмжлүүлгийн тогтолцоо (Early Warning)

- Босго үзүүлэлт, Сэрэмжлүүлэх үйл явдал, Сэрэмжлүүлэх дохио (Threshold, trigger event, alert concept)
- Хэвийн бус үзүүлэлт таних арга (outbreak signals)
- Монголын эрт сэрэмжлүүлэг, анхааруулах дохио ба хариу арга хэмжээний тогтолцоо, орон нутгийн лабораторийн мэдээлэлтэй уялдах байдлууд

Эпидемиологийн суурь ойлголт ба анхан шатны дүн шинжилгээ

- Давтамж, тархвар зүйн суурь үзүүлэлтүүд
- Шинэ тохиолдол, тархалт, Incidence, prevalence, өвчлөлийн нас баралтад хүргэх магадлал, халдварлалтын түвшин (CFR, AR)-ийн тооцоолол
- Анхан шатны өгөгдөлд дүн шинжилгээ хийх (энгийн хандлагын шинжилгээ)
- Орон нутгийн түвшинд дүнг тайлбарлах арга

Суралцахуйн үр дүн

Энэ модулийг амжилттай дүүргэсэн суралцагч дараах чадамжуудыг эзэмшинэ:

- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын үндсэн зарчим, тодорхойлолтыг тайлбарлана.
- Нийгмийн эрүүл мэндийн тандалтын тогтолцоо, бүртгэлийн уламжлалт болон дижитал системийн бүтэц, зарчмыг ойлгоно.
- Тандалтын чанарын үзүүлэлтүүд болон эрт сэрэмжлүүлэх үндсэн зарчим (threshold, alert signal)-ийг тайлбарлана.

- Өөрийн байгууллагын тандалтын мэдээллийг зөв бүртгэж, үнэн зөв, хугацаандаа тайлагнана.
- Анхан шатны тоон мэдээлэлд энгийн дүн шинжилгээ (frequency table, trend, incidence/prevalence) хийнэ.
- Хэвийн бус үзүүлэлт, дэгдэлтийн эрт сэрэмжлүүлгийг илрүүлэн хариу арга хэмжээг эхлүүлэх түвшинд мэдээлнэ.
- Мэдээллийн чанарын доголдлыг тодорхойлон сайжруулах шийдлийн санал боловсруулна.
- Бүртгэлийн үнэн зөв, нягт нямбай байдалд хариуцлагатай хандана.
- Нотолгоонд суурилсан, бодит мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргалтыг өдөр тутмын ажилдаа хэвшүүлнэ.
- Тандалт, дүн шинжилгээний явцад салбар хоорондын хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 8 академик цаг

- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын үндэс
- Тандалтын тогтолцоо, бүртгэл, мэдээлэл цуглуулах арга
- Эпидемиологийн суурь ойлголт, дүн шинжилгээний арга
- Эрүүл мэндийн аюулын эрт сэрэмжлүүлгийн үндсэн зарчим

Семинар — 4 академик цаг

- Орон нутгийн 1 сарын тандалтын тайлангийн бүлгийн хэлэлцүүлэг
- Нотолгооны чанарыг бодит кейс дээр үнэлэх дасгал
- Тохиолдлын тодорхойлолтын бодит жишээ дээр ажиллах

Дадлага — 4 академик цаг

- Энгийн эпидемиологийн тооцоолол (incidence, prevalence, AR, CFR)
- EWARS зарчимд тулгуурласан сэрэмжлүүлэх дохио илрүүлэх дадлага
- Excel/Google Sheets ашиглан анхан шатны дүн шинжилгээ хийх

Бие даалт — 2 академик цаг

- Тандалтын тогтолцооны нэг доголдлыг тодорхойлох
- Шийдлийн 2 хувилбар боловсруулах

Үнэлгээ — 1 академик цаг

- Явцын үнэлгээ №1: Сорил ба тохиолдол шийдвэрлэх даалгавар

4 дүгээр долоо хоног: Модуль 3 Эрсдэлийн үнэлгээ ба Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн удирдлага

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрт сэрэмжлүүлгийг таних, дэгдэлтийн эхний хариу арга хэмжээг зохион байгуулах, IPC (халдварын сэргийлэлт, хяналт), RCCE (эрсдэлийн харилцаа ба олон нийтийн оролцоо)—г хэрэгжүүлэх чадамжийг эзэмшүүлэхэд оршино.

Модуль нь Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, Эрүүл мэндийг хамгаалах, Тандалт, Олон нийтийн оролцоо, Үйлчилгээний чанар зэрэг чиг үүргийн гүйцэтгэлд шаардлагатай чадамжийг эзэмшихэд чиглэнэ.

Үндсэн агуулга

Эрсдэлийн үнэлгээний суурь ойлголт

- Эрсдэл гэж юу вэ? (аюул, өртөгдөх байдал, эмзэг байдал)
- Эрсдэлийн матриц ашиглан эрсдэлийн түвшин тогтоох
- Нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийн төрлүүд
- Орон нутгийн эрсдэлийн үнэлгээний мэдээллийн эх үүсвэр

Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн удирдлага

- Онцгой байдлын үеийн удирдлагын мөчлөг
- Бэлтгэл байдал (Preparedness)
- Хариу арга хэмжээ (Response)
- Сэргээх үе шат (Recovery)
- Урьдчилан сэргийлэх (Prevention/Mitigation)
- Шуурхай удирдлагын тогтолцоо (Incident Management System – IMS → Орон нутгийн шуурхай удирдлагын зохион байгуулалт)
- Дэгдэлтийн менежментийн 8 алхам
- Газар дээрх үнэлгээ (rapid field assessment)

Халдварын сэргийлэлт, хяналт (IPC)

- ХСХ-ын үндсэн зарчим
- Гар ариун цэвэр, амны хаалт, хог хаягдлын менежмент
- Дэгдэлтийн үед байгууллагын дотоод зохион байгуулалт
- Аймаг, сумын түвшний ХСХ-ын чадамжийн шаардлага

Эрсдэлийн харилцаа ба олон нийтийн оролцоо (RCCE)

- Олон нийттэй зөв ойлголт түгээх зарчим
- Түргэн шалгуур: “3C” модел — Correct message, Clear message, Credible messenger
- Далд мэдээллийг илрүүлэх (rumour tracking)

- Орон нутгийн удирдлага, иргэд, байгууллагын оролцоог идэвхжүүлэх

Дэгдэлтийн үеийн салбар хоорондын хамтын ажиллагаа

- Салбарын хяналт, усан хангамж, байгаль орчин, мал эмнэлэг
- Орон нутгийн зөвлөлтэй хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагаа

Суралцахуйн үр дүн

- Нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийн төрлүүдийг ялган танина.
- Эрсдэлийн үнэлгээний арга, матриц, үнэлгээний шатлалыг тайлбарлана.
- Онцгой байдлын үеийн удирдлагын мөчлөг, үндсэн зарчмуудыг ойлгоно.
- ХСХ-ийн суурь зарчмуудыг тайлбарлана.
- Эрсдэлийн харилцаа ба олон нийтийн оролцооны суурь зарчмуудыг тайлбарлана.
- Эрсдэлийн үнэлгээ хийх (simple risk assessment matrix).
- EWARS болон орон нутгийн тандалтын мэдээллээр дэгдэлтийн хариу арга хэмжээ эхлүүлэх.
- Газар дээрх түргэн үнэлгээ хийх (rapid assessment checklist ашиглах).
- Олон нийтийн оролцоо, эрсдэлийн харилцааны төлөвлөгөөг боловсруулах.
- ХСХ-ын үндсэн арга хэмжээг байгууллагын түвшинд хэрэгжүүлэх.
- Онцгой байдлын үед шуурхай, мэргэжлийн, хариуцлагатай ханддаг болно.
- Салбар хоорондын хамтын ажиллагааг эрхэмлэдэг, идэвхтэй оролцоотой байна.
- Эрсдэлийг урьдчилан харж, сэргийлэх сэтгэлгээтэй ажиллана.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 8 академик цаг

- Эрсдэлийн үнэлгээний үндэс
- Онцгой байдлын үеийн удирдлагын мөчлөг
- Дэгдэлтийн хариу арга хэмжээний алгоритм
- Олон нийтийн оролцоо, эрсдэлийн харилцааны үндэс
- ХСХ-ын үндэс

Семинар — 4 академик цаг

- Кейстэй ажиллах: “Аймагт суулгалтын дэгдэлт үүссэн”
- Эрсдэлийн матриц боловсруулах бүлгийн ажил
- Олон нийтийн оролцоо, эрсдэлийн харилцааны мессеж боловсруулах дасгал

Дадлага — 4 академик цаг

- Дэгдэлтийн газар дээрх үнэлгээний симуляци
- ХСХ-ын зөв дадлага (гар ариун цэвэр, хамгаалах хэрэгсэл)
- Орон нутгийн нөхцөлд хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргах

Бие даалт — 2 академик цаг

- Орон нутгийн түвшинд тулгамдсан 1 эрсдэлийг тодорхойлж, “Эрсдэлийн үнэлгээний хуудас” бөглөсөн богино тайлан.

5 дугаар долоо хоног: Модуль 4 Эрүүл мэндийг дэмжих ба Зан үйлийн өөрчлөлтийн шинжлэх ухаан

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн ажилтнуудад хүн амын эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, зан үйлийн эрсдэлийг бууруулах, хувь хүн болон бүлгийн түвшинд зан үйлийн өөрчлөлтөд чиглэсэн үр дүнтэй арга зүйг хэрэглэх, төр-орон нутаг-олон нийтийн оролцоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх чадамжийг эзэмшүүлэхэд оршино.

Энэ модуль нь Эрүүл мэндийг дэмжих, Олон нийтийн оролцоо ба нийгмийн хамтын ажиллагаа болон Өвчнөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь чадваруудыг бэхжүүлнэ.

Үндсэн агуулга

Эрүүл мэндийг дэмжих (Health Promotion)-ийн суурь ойлголт

- Эрүүл мэндийг дэмжих таван багана
- Бодлого (healthy policy)
- Орчны дэмжлэг (supportive environment)
- Олон нийтийн оролцоо (community action)
- Хүний чадавхийг бэхжүүлэх (skills development)
- Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлийг өөрчлөх (reorienting health services)
- Монгол Улсын эрүүл мэндийг дэмжих бодлого, хууль эрх зүй
- Анхан шатанд хэрэгжүүлэх боломжтой эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа

Зан үйлийн өөрчлөлтийн шинжлэх ухаан

- Зан үйл гэж юу вэ? (determinants of behaviour)
- Хүн амын эрүүл зан үйлийг тодорхойлогч хүчин зүйлс
- Хамгийн түгээмэл хэрэглэгддэг зан үйлийн онол, загвар:
 - o Health Belief Model – Эрүүл зан үйлийн ойлголтын загвар
 - o Theory of Planned Behaviour – Төлөвлөсөн зан үйлийн онол
 - o Stages of Change Model – Зан үйлийн өөрчлөлтийн үе шатны загвар

- COM-B загвар – Чадамж–боломж–урамшуулалд суурилсан зан үйлийн загвар

Хувь хүн ба бүлгийн түвшинд зан үйл өөрчлөх арга зүй

- Богино хугацааны зан үйлийн зөвлөгөө (brief intervention)
- 5A арга (Assess, Advise, Agree, Assist, Arrange → Үнэлэх, зөвлөх, тохирох, дэмжих, дахин төлөвлөх)
- Эрсдэлт зан үйлийг бууруулах (тамхи, архи, давс, хөдөлгөөнгүй байдал, хооллолт)
- Өөрийгөө удирдах арга (self-management)
- Сэдэлжүүлэх ярилцлага (Motivational interviewing)–ийн үндэс

Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа

- Нийгмийн зан үйлийн өөрчлөлт
- Mass media, social media–ийн зөв хэрэглээ
- Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн сургалт, арга хэмжээ зохион байгуулах
- Хүүхэд, өсвөр үе, өндөр настан, эрсдэлт бүлгүүдэд чиглэсэн агуулгын онцлог
- Сайн дурын бүлэг, иргэний нийгмийн оролцоо

2.5 Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, кампанит ажил төлөвлөх

- Асуудал тодорхойлох – зорилтот бүлэг сонгох
- Зан үйлийн өөрчлөлтийн логик загвар (Behavioural pathway model)
- Мессеж боловсруулах зарчим
- Нөлөөллийн сувгууд сонгох
- Хэрэгжилтийн төлөвлөгөө гаргах
- Үр нөлөө үнэлэх (evaluation)

Суралцахуйн үр дүн

- Эрүүл мэндийг дэмжих суурь ойлголт, зарчим, орчин үеийн чиг хандлагыг тайлбарлана.
- Зан үйлийн өөрчлөлтийн онол, загваруудын ялгаа, зорилго, хэрэглээг ойлгоно.
- Хүн амын зан үйлийг өөрчлөхөд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлж чадна.
- Хувь хүнд эрсдэлт зан үйлийг өөрчлөх богино зөвлөгөө өгөх.
- COM-B ба Stages of Change загвар ашиглан зан үйлийн үнэлгээ хийх.
- Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх.

- Эрүүл мэндийг дэмжих мессеж боловсруулах (clear, correct, culturally appropriate).
- Сайн дурын бүлэг, олон нийтийг оролцуулах төлөвлөгөө боловсруулах.
- Суралцагч эрүүл зан үйлийн үлгэрлэгч байх, харилцаанд эерэг, дэмжигч хандлагатай ажиллана.
- Олон нийтийг буруутгахгүй, ялгаварлалгүй, тэгш хандлагыг хэвшүүлнэ.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 8 академик цаг

- Эрүүл мэндийг дэмжих суурь ойлголт
- Зан үйлийн өөрчлөлтийн онол, COM-B, Stages of Change
- Зөвлөгөө өгөх, сэдэлжүүлэх ярилцлагын үндэс
- Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн дэмжлэг

Семинар — 4 академик цаг

- Кейстэй ажиллах: “Архи, давсны хэрэглээ өндөр багийн амьдралын хэв маяг”
- COM-B загвараар зан үйл тодорхойлох
- Мессеж боловсруулах бүлгийн ажил

Дадлага — 4 академик цаг

- 5А арга ашиглан нэг суралцагчид эрсдэлт зан үйлийн зөвлөгөө өгөх role-play
- Нийгмийн зан үйлийг өөрчлөх кампанит ажлын мини төлөвлөгөө гаргах
- Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх боломжит сургалтын арга боловсруулах

Бие даалт — 2 академик цаг

- Нэг эрсдэлт зан үйл сонгон (тамхи, архи, идэвхи багатай байдал, хооллолт), COM-B үнэлгээ хийж богино төлөвлөгөө гаргах.

6 дугаар долоо хоног: МОДУЛЬ 5 Олон нийтийн оролцоо ба нийгмийн хамтын ажиллагаа

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад олон нийтийн оролцоог дэмжих, нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх, орон нутгийн иргэд, өрхийн идэвхтэй бүлэг, сайн дурынхантай хамтран ажиллах, олон нийтийн оролцоонд суурилсан эрүүл мэндийн үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэх чадамжийг эзэмшүүлэхэд оршино.

Модуль нь Олон нийтийн оролцоо ба нийгмийн хамтын ажиллагаа, мөн Эрүүл мэндийг дэмжих, Онцгой байдал, Тандалтын үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадамжид шууд хамаарна.

Үндсэн агуулга

Олон нийтийн оролцооны үндсэн зарчим

- Олон нийтийн оролцоо гэж юу вэ?
- Идэвхтэй оролцооны 5 түвшин (information → consultation → involvement → collaboration → empowerment)
- Олон нийтийн оролцоо ба эрүүл мэндийн тэгш байдал
- Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн бодлогод олон нийтийн оролцооны байр суурь

Орон нутгийн нийгмийн бүтэц, бүлгүүдийг тодорхойлох

- Нийгмийн бүлгийн зураглал гаргах (community mapping)
- Сайн дурын бүлэг, залуучуудын клуб, эмэгтэйчүүдийн зөвлөл, өрхийн зөвлөл
- Эмзэг бүлгийн оролцоог хангах (gender, disability, minority groups)
- Төр–Олон нийт–Иргэний нийгмийн гурвалсан бүтэц

Нийгмийн хамтын ажиллагааны арга зүй

- Хамтын шийдвэр гаргалт (co-decision)
- Хамтран төлөвлөлт (co-design)
- Хамтран хэрэгжилт (co-delivery)
- Нийгмийн үйл ажиллагаа (social mobilization)
- Олон нийтийн манлайлал ба идэвхжүүлэлт

Community engagement үйл ажиллагаа төлөвлөх

- Оролцогч талуудын шинжилгээ (stakeholder analysis)
- Олон нийтийн хэрэгцээг тодорхойлох (needs assessment)
- Community action plan боловсруулах
- Сайн дурынхантай ажиллах зарчим — сонгон шалгаруулалт, хуваарь, хариуцлага
- Эрүүл мэндийн сайн дурын багийн бүтэц (CHW model)

Онцгой байдлын үед олон нийтийн оролцоо

- Эрсдэлийн харилцаа (RCCE) ба оролцоо
- Trigger event илрэх үед оролцооны үүрэг
- Олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглах (сумын радио, Фэйсбүүк групп...)
- Цуурхлын тандалт (rumour tracking)
- Хэвлэл мэдээлэлтэй ажиллах зарчим

Суралцахуйн үр дүн

- Олон нийтийн оролцоо, нийгмийн хамтын ажиллагааны үндсэн зарчмыг тайлбарлана.

- Орон нутгийн нийгмийн бүлгүүд, эмзэг бүлгийг таньж тодорхойлно.
- Community engagement үйл ажиллагааны төлөвлөлтийн үе шатыг ойлгоно.
- Оролцогч талуудын шинжилгээ (stakeholder analysis) хийх.
- Нийгмийн бүлгийн зураглал (community mapping) гаргах.
- Олон нийтийн оролцоонд тулгуурласан эрүүл мэндийн үйл ажиллагаа төлөвлөх.
- Сайн дурынхантай үр дүнтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах.
- Онцгой байдлын үед олон нийттэй харилцах (RCCE).
- Иргэдийг шийдвэр гаргалтад тэгш оролцуулах хандлагатай болно.
- Олон нийтийн дуу хоолойг хүндэтгэх, арга хэмжээний хамтрагчаар үзэх хандлага төлөвшинө.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 6 академик цаг

- Олон нийтийн оролцоо, нийгмийн хамтын ажиллагааны үндсэн ойлголт
- Нийгмийн бүлгийн зураглал гаргах ба оролцогч талуудын шинжилгээ
- Нийгмийн хамтын ажиллагаа, сайн дурынхны үүрэг
- Олон нийтийн оролцоо, нийгмийн хамтын ажиллагааны ба онцгой байдлын үеийн оролцоо

Семинар — 4 академик цаг

- Бүлгийн ажил: “Манай баг/сумын Нийгмийн бүлгийн зураглал гаргах”
- Оролцогч талуудын матриц боловсруулах дасгал
- Сайн дурынхантай ажиллах мини-кейс

Дадлага — 4 академик цаг

- Нийгмийн бүлгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Олон нийтийн оролцоо, нийгмийн хамтын ажиллагаанд ашиглах мессеж боловсруулах (3С зарчмаар: зөв – тодорхой – итгэлтэй эх сурвалцаар)
- Нийгмийн бүлгүүдэд чиглэсэн богино сургалтын хөтөлбөр загварчлах

Бие даалт — 2 академик цаг

- Өөрийн байгууллагын “Олон нийтийн оролцоог сайжруулах боломж” сэдвээр 1 хуудас дүгнэлт
- Нийгмийн бүлгийн зураглал гаргах

Үнэлгээ — 1 академик цаг

- Явцын үнэлгээ №2: богино сорил + оролцогч талуудын шинжилгээ хийх дасгал

7 дугаар долоо хоног: Модуль 7 Салбар хоорондын хамтын ажиллагаа ба эрүүл мэндийн нөлөөллийн шийдвэр (*Intersectoral collaboration & Health impact decision-making*)

Модулийн зорилго

Эрүүл мэндийн ажилтнуудад эрүүл мэндэд нөлөөлөгч хүчин зүйлсийг олон салбарын уялдаа холбоотой үнэлж, орон нутгийн түвшинд салбар хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах үйл явцад эрүүл мэндийн үнэлгээ (Health Impact Assessment – HIA) хийх суурь чадварыг эзэмшүүлэх. Мөн эрүүл мэндийг бүх бодлогод тусгах (“Health in All Policies”) зарчимд тулгуурлаж, сум/хороо, өрхийн ЭМТ-ийн түвшинд бодит хамтын ажиллагаа хөгжүүлэх, орон нутгийн зөвлөл, комисс, багуудад үр дүнтэй оролцох чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

Үндсэн агуулга

Эрүүл мэндийн нөлөөлөгч хүчин зүйлс ба салбар хоорондын хамаарал

- Эрүүл мэндийн өргөн тодорхойлолт
- Нийгмийн тодорхойлогч хүчин зүйлс (social determinants of health)
- Орон нутгийн эрүүл мэндийн байдалд нөлөөлдөг салбарууд:
- Боловсрол
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- Байгаль орчин, усан хангамж
- Хүнс, хөдөө аж ахуй
- Зам тээвэр, хот төлөвлөлт
- Иргэний хамгаалалт, онцгой байдал

“Эрүүл мэндийг бүх бодлогод тусгах” зарчим (Health in All Policies – HiAP)

- HiAP-ийн зорилго, шалгуур
- Монгол Улсын бодлогын баримт бичгийн зохицуулалт (ТХЗ 3, 10, 11)
- Орон нутгийн түвшинд ашиглах боломжтой механизмүүд:
- Аймаг/дүүргийн НЭМ зөвлөл
- Сумын засаг захиргааны эрүүл мэндийн хороо
- Салбар хоорондын хамтарсан баг

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (HIA) – суурь ойлголт

- HIA-ийн зорилго, үе шат:
 - o Screening — Нөлөөлөх эсэхийг шалгах
 - o Scoping — Үнэлгээний хүрээ тогтоох
 - o Assessment — Нөлөөллийг үнэлэх

- Recommendations — Шийдвэрийн зөвлөмж боловсруулах
- Monitoring — Хэрэгжилтийг хянах
- Орон нутгийн ЭМТ-д хийх боломжит HIA жишээ:
 - Ундны усны эх үүсвэр шилжүүлэх
 - Сургууль, цэцэрлэгийн хүнсний үйлчилгээ
 - Зам барилгын агаарын бохирдлын нөлөөлөл
 - Малын гоц халдварт өвчний дэгдэлтийн үеийн хүн малын эрүүл мэндийн уялдаа

Салбар хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй

- Stakeholder mapping (оролцогч талуудын зураглал)
- Хамтын ажиллагааны түвшин: мэдээлэх – зөвлөлдөх – хамтран хэрэгжүүлэх
- Олон талын уулзалт зохион байгуулах арга зүй
- Зөрчил тохиролцоо, сонирхлын зөрчлийг удирдах
- Олон нийт, иргэний нийгмийн оролцоо
- Тохиролцоо (MoU), ажлын төлөвлөгөө боловсруулах

Хамтын ажиллагааны нэгтгэсэн төлөвлөлт ба бодлогын хэрэгжилт

- Хамтарсан төлөвлөгөө боловсруулах
- Салбар хоорондын индикатор тогтоох
- “Нэг эрүүл мэнд” (One Health) зарчимтай уялдуулах
- Бодит жишээ: Хүүхдийн осол гэмтэл, архины хэрэглээ, амьсгалын замын агаарын бохирдол, хүнсний аюулгүй байдлын хяналт

Суралцахуйн үр дүн

- Эрүүл мэндийн нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийн нөлөөг тайлбарлана.
- Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний (HIA) үе шатыг ойлгоно.
- HiAP болон One Health зарчмуудын орон нутгийн хэрэгжилтийг мэднэ.
- Салбар хоорондын оролцогчдыг тодорхойлох, stakeholder mapping хийх.
- HIA-ийн суурь үнэлгээ хийх (screening–scoping–assessment).
- Хамтарсан уулзалт төлөвлөх, санал нэгтгэх, шийдвэр гаргалтад оролцох.
- Санал зөвлөмж, богино бодлогын хураангуй (policy brief) боловсруулах.
- Хамтын ажиллагааны төлөвлөгөө (joint plan) гаргах.
- Олон салбарын хамтын ажиллагааг дэмжих, бусдыг хүндэтгэх харилцаанд суралцах.
- Өргөн хүрээний шийдвэр эрүүл мэндэд нөлөөлдөг гэдгийг ухамсарлах.
- Ил тод, нотолгоонд суурилсан хамтын шийдвэрийг эрхэмлэх.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 5 академик цаг

- HiAP зарчим, салбар хоорондын уялдаа
- HIA-ийн үе шат
- Салбар хоорондын бүтэц, оролцогч талуудын үүрэг
- One Health ба орон нутгийн хэрэгжилт

Семинар — 3 академик цаг

- HIA кейс (ус, агаар, хүнсний аюулгүй байдал гэх мэт)
- Салбар хоорондын зөрчил, шийдвэрийн симуляци

Дадлага — 3 академик цаг

- Орон нутгийн нэг асуудлаар HIA screening хийх
- Хамтын ажиллагааны төлөвлөгөө (joint plan) боловсруулж үзэх
- Олон нийтийн санал цуглуулах

Үнэлгээ — 1 академик цаг

- HIA-ийн үе шат тодорхойлох
- оролцогч талуудын зураглал
- Бодлогын тойм боловсруулах богино даалгавар

8 дугаар долоо хоног: Модуль 6 Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, засаглал ба бодлого төлөвлөлт

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн удирдлага, стратегийн төлөвлөлт, засаглалын зарчим, оролцогч талуудын менежмент, бодлого боловсруулах үе шатыг эзэмшүүлэх, мөн орон нутгийн түвшинд нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт хийх чадамжийг төлөвшүүлэхэд оршино.

Модуль нь Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, засаглал, Салбар хоорондын төлөвлөлт, санхүүжилт, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай чадамжууд болох харилцах, хамтын ажиллагаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын чиг үүрэгт хамаарах чадамжуудтай уялдана.

Үндсэн агуулга

Нийгмийн эрүүл мэндийн удирдлагын (leadership) үндсэн ойлголт

- Удирдлагын зарчим, стратегийн манлайллын үүрэг
- Эрүүл мэндийн байгууллагын бодлого, төлөвлөлтийн систем
- Шийдвэр гаргалтын түвшин
- Орон нутгийн түвшинд удирдлагын үнэ цэнэ

Засаглал (governance) ба хариуцлагын тогтолцоо

- Засаглалын 6 үндсэн зарчим: ил тод байдал, хариуцлага, оролцоо, үр ашиг, шударга байдал, эрх тэгш байдал
- Эрүүл мэндийн байгууллагын дотоод засаглал: журам, зохицуулалт, ажлын урсгал
- Хууль эрх зүйн орчин

Оролцогч талуудын удирдлага

- Оролцогч талуудын ангилал: шийдвэр гаргагч, нөлөөлөгч, дэмжигч, ашиг хүртэгч
- Оролцогч талуудын зураглал гаргах – ашиг сонирхлын матриц
- Харилцаа, хамтын ажиллагааны стратеги
- Зөрчил, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах

Бодлого боловсруулах үндсэн үе шат

- Нийгмийн эрүүл мэндийн асуудлын тодорхойлолт (problem definition)
- Нотолгоо цуглуулах (evidence gathering)
- Бодлогын хувилбар боловсруулах (policy options)
- Бодлогын товч танилцуулга (policy brief) бичих
- Хэрэгжилт, мониторинг, үнэлгээ

Орон нутгийн түвшний төлөвлөлт

- Жил, улирал, сарын төлөвлөгөө боловсруулах
- “Зорилт–Үйл ажиллагаа–Үзүүлэлт–Эх үүсвэр–Хариуцах нэгж” загвар
- Үйл ажиллагааны төлөвлөгөөний өртөг тооцох

Суралцахуйн үр дүн

- Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, засаглалын гол зарчмуудыг тайлбарлана.
- Бодлого, төлөвлөлтийн үе шатыг нэрлэж, тэдгээрийн уялдааг ойлгоно.
- Оролцогч талуудын менежментийн үндсэн зарчмыг мэддэг болно.
- Орон нутгийн түвшинд оролцогч талуудын шинжилгээ хийнэ.
- Нотолгоонд суурилсан бодлогын товч танилцуулга боловсруулна.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө (action plan) боловсруулж өртөг тооцно.
- Жилийн төлөвлөгөөний бүтцийг үнэлж сайжруулах санал гаргана.
- Ил тод, хариуцлагатай шийдвэр гаргах зарчмыг баримталдаг болно.
- Олон талын оролцоог дэмжсэн, хамтын шийдвэр гаргалтыг эрхэмлэсэн хандлага төлөвшинө.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 4 академик цаг

- НЭМ-ийн удирдлагын үүрэг, стратегийн манлайлал
- Засаглалын тогтолцоо, хариуцлагын зарчим
- Бодлого боловсруулах циклийн үндсэн үе шат
- Орон нутгийн төлөвлөлтийн загварууд

Семинар — 4 академик цаг

- Бодлогын асуудлыг тодорхойлох бүдүүвч
- Бодлогын товч танилцуулгын (policy brief) бүтэц боловсруулах файл дээр ажиллах

Дадлага — 4 академик цаг

Бие даалт — 2 академик цаг

“Манай байгууллагын НЭМ төлөвлөлтийн сайжруулах боломж” сэдвээр бодлогын товч бичих

Модуль 8 Нийгмийн эрүүл мэндийн санхүүжилт ба нөөцийн оновчтой удирдлага

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр, төсөвлөлт, зардлын тооцоолол, нөөц хуваарилалт, хөрөнгө болон материаллаг нөөцийн удирдлагын үндсэн зарчмуудыг эзэмшүүлэх, улмаар байгууллагын түвшинд илүү үр ашигтай төлөвлөлт, хариуцлагатай нөөцийн менежмент хийх чадварыг төлөвшүүлэхэд оршино.

Модуль нь EPHF-4 (Салбар хоорондын төлөвлөлт, санхүүжилт ба менежмент), EPHF-10 (Үйлчилгээний чанар ба тэгш хүртээмж), мөн байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн үр ашиг, ил тод байдал, хариуцлагын зарчмуудтай уялдана.

Үндсэн агуулга

Нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо

- ЭМ-ийн төсөв, санхүүжилтийн үндсэн эх үүсвэр
 - o Төсвийн санхүүжилт
 - o Эрүүл мэндийн даатгал
 - o Төсөл, хөтөлбөр, түншлэлийн санхүүжилт
- Санхүүжилтийн зарчим: үр ашиг, тэгш байдал, тогтвортой байдал

- Анхан шатны түвшний санхүүжилтийн онцлог

Нийтлэг төсөвлөлт ба зардлын тооцоолол

- Жилийн төсөв боловсруулах үе шат
- Үйл ажиллагааны өртөг тооцох арга (activity-based costing)
- Шууд ба шууд бус зардал
- НЭМ-ийн хөтөлбөрийн өртгийн тооцоо

Нөөцийн оновчтой хуваарилалт

- Хүний нөөц, материаллаг нөөц, тоног төхөөрөмжийн төлөвлөлт
- Нөөцийн хомсдолыг нөхөх стратеги (prioritization, redistribution)
- Эрсдэлийн нөхцөлд (онцгой байдал) нөөцийн удирдлага

Хөрөнгө, материал, тоног төхөөрөмжийн бүртгэл ба хяналт

- Хөрөнгийн тооллого, ангилал
- Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Эмийн болон эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, хэрэглээний зохицуулалт
- Нийлүүлэлтийн сүлжээ (supply chain)–ний зохион байгуулалт
- “First-expire–first-out” (FEFO) зарчим

Ил тод байдал, хариуцлага ба тайлагнал

- Санхүүгийн тайлан, хяналт
- Олон нийт, байгууллагын өмнө хариуцлага хүлээх тогтолцоо
- Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
- Эрүүл мэндийн ажилтны төсөв, нөөцийн удирдлагад оруулах хувь нэмэр

Суралцахуйн үр дүн

- Нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн үндсэн зарчим, эх үүсвэрүүдийг тайлбарлана.
- Төсөвлөлтийн үе шат, өртөг тооцооллын арга зүйг мэднэ.
- Нөөцийн хуваарилалтын оновчтой зарчмыг танина.
- Хөтөлбөр, үйлчилгээний өртгийг тооцох аргачлалыг хэрэглэнэ.

- Оролцогч талуудтай хамтран төсвийн хэрэгцээг тодорхойлно.
- Нийлүүлэлтийн сүлжээг үнэлж, сайжруулах санал гаргана.
- Байгууллагын нөөцийн тайлан бэлтгэнэ.
- Ил тод, хариуцлагатай санхүүгийн үйл ажиллагааг эрхэмлэнэ.
- Нөөцийн хэмнэлт, үр ашгийг тооцон ажиллах хандлага төлөвшинө.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 4 академик цаг

- НЭМ-ийн санхүүжилтийн зарчим, тогтолцоо
- Өртөг тооцооллын үндэс
- Нөөцийн оновчлол, төлөвлөлтийн логик
- Хөрөнгө ба тоног төхөөрөмжийн удирдлага

Дадлага — 4 академик цаг

- Байгууллагын нөөцийн (equipment, medicine, consumables) аудит хийх
- Нийлүүлэлтийн сүлжээний дүрслэл зурах
- Нэг хөтөлбөр дээр нөөцийн ашиглалтын тооцоо хийх

Бие даалт — 2 академик цаг

- 1 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурласан жижиг төсөв боловсруулах
- Нөөцийн менежментийн сайжруулалтын санал бичих

9 дүгээр долоо хоног: Модуль 8 Эрүүл мэндийн мэдээллийн систем ба дүн шинжилгээ

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад мэдээлэл цуглуулах, бүртгэх, боловсруулах, тайлагнах, эрт сэрэмжлүүлэх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад мэдээлэл ашиглах суурь чадварыг эзэмшүүлэхэд оршино. Мөн дүн шинжилгээ хийх үндсэн аргуудыг эзэмшүүлж, өгөгдлийг орон нутгийн түвшинд үйл ажиллагаа төлөвлөлт, тандалт, тайлагнал, эрсдэлийн эрт илрүүлэлтэд ашиглах чадварыг хөгжүүлнэ.

Модуль нь EPHF-1 (Нийгмийн эрүүл мэндийн тандалт), EPHF-9 (Мэдээллийн тогтолцоо), EPHF-11 (Нотолгоо, судалгаа), мөн анхан шатны байгууллагын гүйцэтгэлийн мэдээллийн удирдлага, эрт сэрэмжлүүлэх системд нийцнэ.

Үндсэн агуулга

Эрүүл мэндийн мэдээллийн систем (ЭММС)–ийн үндэс

- Эрүүл мэндийн мэдээллийн системийн зорилго, бүрэлдэхүүн хэсэг
- Анхан шатны түвшний мэдээллийн урсгал
- Дотоод болон гадаад мэдээллийн эх сурвалц
- “Нэг мэдээлэл–нэг эх сурвалц” зарчим

Өгөгдөл цуглуулах ба бүртгэл

- Өдөр тутмын бүртгэл (өвчлөл, үйлчлэгчийн мэдээлэл, дархлаажуулалтын бүртгэл, ААН/Дамжуулагч тандалт)
- Өгөгдлийн чанарын шалгуур (нарийвчлал, бүрэн байдал, давтамж, уялдаа)
- “Алдаа илрүүлэх матриц” ашиглах

Өгөгдөл боловсруулах ба анхан шатны шинжилгээ

- Индикатор тооцоолол:
 - o Шинэ тохиолдол (incidence)
 - o Тархалт (prevalence)
 - o Өртөгдөх түвшин (attack rate)
 - o Нас баралт (case fatality ratio–CFR)
- График, хүснэгт, чиг хандлага зурж унших
- Статистикийн үндсэн аргууд (дундаж, медиан, хувиар)

Эрүүл мэндийн тандалтын мэдээлэл

- EWARS — “Эрт сэрэмжлүүлэх ба хариу арга хэмжээний систем”
 - Босго түвшин (threshold), дохио (alert), эхний үйл явдал (trigger event)-ийн ойлголтууд
 - Өвчний хяналтын 5 алхам
 - Орон нутгийн тандалтын үүрэг

Мэдээллийн хэрэглээ ба тайлагнал

- Тайлангийн төрлүүд (өдрийн, долоо хоногийн, сарын, жилийн)
- ICD-10 кодын зохистой хэрэглээ
- Шийдвэр гаргалтад мэдээлэл ашиглах
- Шийдвэр гаргагчдад зориулсан богино мэдээллийн хураангуй (policy note, short brief) бэлтгэх

Data literacy ба мэдээллийн ёс зүй

- Хувь хүний мэдээллийн нууцлал
- Мэдээлэл ашиглалтын ёс зүй
- Буруу тайлагналын эрсдэл, урьдчилан сэргийлэлт
- Хариуцлагатай мэдээллийн соёл төлөвшүүлэх

Суралцахуйн үр дүн

- Эрүүл мэндийн мэдээллийн системийн зорилго, бүтэц, мэдээллийн урсгалыг тайлбарлана.
- Тандалт, өгөгдлийн чанарын шалгуур, EWARS-ийн үндсэн ойлголтыг мэднэ.
- Индикатор тооцоолох зарчмыг ойлгоно.
- Өгөгдөл цуглуулах, бүртгэл хөтлөх, анхан шатны шинжилгээ хийх.
- Өгөгдлөөс индикатор тооцох (incidence, prevalence, CFR, AR).
- График, чиг хандлага гаргаж тайлбарлах.
- Тайлан боловсруулах, шийдвэр гаргахад мэдээлэл ашиглах.
- EWARS дохиог илрүүлж шуурхай тайлагнах.
- Мэдээллийн нууцлал, ёс зүйг эрхэмлэх.
- Нарийн, үнэн зөв бүртгэл хөтлөх хариуцлагатай хандлага төлөвших.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 6 академик цаг

- ЭММС-ийн үндэс ба бүтэц
- Индикатор тооцооллын арга
- EWARS-ийн зарчим, босго түвшин
- Мэдээллийн хэрэглээний үндэс

Семинар — 4 академик цаг

- Долоо хоногийн тандалтын тайлантай ажиллах
- Өгөгдлийн чанар үнэлэх дасгал
- Индикатор тооцох бодлого
- Алдаа засварлах кейс

Дадлага — 4 академик цаг

- Excel ашиглан өгөгдөл цэвэрлэх
- График, чиг хандлага гаргах
- EWARS alert илрүүлэх бодит жишээ
- Мэдээллийн тайлан бичих (short brief)

Бие даалт — 2 академик цаг

- Сонгосон нэг индикатор дээр тайлан бэлтгэх
- Өгөгдлийн чанарын үнэлгээ хийх

Үнэлгээ — 1 академик цаг

Явцын үнэлгээ №3

- Зардлын тооцоолол + нөөцийн үнэлгээний хосолсон даалгавар
- Богино тест (10 асуулт)
- Индикатор тооцох
- График унших
- EWARS дохио тайлагнах богино кейс

10 дугаар долоо хоног: Модуль 10 Орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл мэнд ба хүнсний аюулгүй байдал

Модулийн зорилго

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад орчны эрүүл мэндийн эрсдэл (агаар, ус, хөрс, бохирдол), хөдөлмөрийн орчны аюул, хүнсний аюулгүй байдлын эрт илрүүлэлт, эрсдэлийн үнэлгээ, хяналт, шуурхай мэдээлэх суурь чадамжийг эзэмшүүлэх. Мөн орон нутгийн түвшинд орчны эрүүл мэндийн тандалт, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ, олон нийтийн мэдээлэл, хариу арга хэмжээтэй уялдуулан ажиллах чадвар төлөвшүүлэх.

Модуль нь EPHF-5 (Эрүүл мэндийг хамгаалах), EPHF-6 (Өвчинөөс сэргийлэлт), EPHF-7 (Эрүүл мэндийг дэмжих), EPHF-12 (Эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, технологи) чиг үүргүүдтэй уялдана.

Үндсэн агуулга

Орчны эрүүл мэндийн үндэс

- Орчны эрүүл мэндийн тодорхойлолт, ач холбогдол
- Агаарын бохирдол (PM2.5, PM10), дотоод орчны агаар
- Ундны усны аюулгүй байдлын шалгуур
- Хог хаягдлын эрүүл ахуйн менежмент
- Хөрсний бохирдол, химийн бодисын эрсдэл
- Орчны эрүүл мэндийн тандалтын үндсэн үзүүлэлтүүд

Орчны эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ

- Эрсдэлийн хүчин зүйл тодорхойлох
- Эрсдэлийн матриц ашиглах

- Орон нутгийн түвшинд хяналт–сорьц авах ойлголт
- Өндөр эрсдэлт бүлгийг ангилан үнэлэх

Хөдөлмөрийн эрүүл мэнд (Occupational health)

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэс
- Эрсдэлийн төрлүүд:
- Физик (чихрийн дуу чимээ, гэрэлтүүлэг, температур)
- Химийн (уур, хий, бодис)
- Биологийн (мөөгөнцөр, халдвар)
- Эргономик ба сэтгэлзүйн ачаалал
- ХАБЭА тандалт, ажилтан бүрт хийх эрүүл мэндийн үзлэг
- Мэргэжлээс шалтгаалах өвчний илрүүлэлт
- Эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн эрүүл мэнд

Хүнсний аюулгүй байдал

- Хүнсний эрүүл ахуй, эрүүл хүнс–эрүүл амьдрал
- Хүнсний эрсдэлийн төрлүүд:
- Биологийн
- Химийн
- Физик
- Хууль бус нэмэлт, хуурамч бүтээгдэхүүн
- Хүнсний үйлдвэрлэл, худалдааны хяналтын анхан шат
- Хүнсний гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлтийн эрүүл ахуй
- Хоол боловсруулах үеийн аюулгүй байдал (Household food safety)

Шуурхай хариу арга хэмжээ ба тайлагнал

- Орчны эрүүл мэндийн яаралтай нөхцөл
- Химийн бодисын хордлого, хоолны хордлого, усны бохирдлын үеийн анхан шатны арга хэмжээ
- “Нэг эрүүл мэнд” (One Health) хандлага

- Шуурхай мэдээлэх сувгууд (H-reporting, MHL, NCCD түвшин)
- Олон нийтэд зөв мэдээлэл өгөх (RCCE)

Суралцахуйн үр дүн

- Орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын үндсэн ойлголт, хууль эрх зүйн орчныг тайлбарлана.
- Эрсдэлийн төрлүүд, тэдгээрийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг мэднэ.
- Хүнсний аюулгүй байдлын гол шалгуур, хордлогын эрт илрүүлэлтийн зарчмыг ойлгоно.
- Орчны болон хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийг таних, үнэлэх.
- Хүнсний аюулгүй байдлын зөрчил илрүүлэх, анхан шатны зөвлөгөө өгөх.
- Аюулын үед шуурхай хариу арга хэмжээ авах (хоолны хордлого, химийн хордлого, усны бохирдол).
- Тохирох сувгаар мэдээлэл тайлагнах, RCCE зарчмаар олон нийтэд мэдээлэл өгөх.
- Эрүүл мэндийн зөв дадал хэвшүүлэх арга барил ашиглан олон нийтэд зөвлөгөө өгөх.
- Орчныг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг дэмжих хариуцлагатай хандлага төлөвших.
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, ажилтны аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих.
- Нэг эрүүл мэндийн зарчмыг эрхэмлэн салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 6 академик цаг

- Орчны эрүүл мэндийн суурь ойлголт
- ХАБЭА–гийн үндэс, мэргэжлээс шалтгаалах өвчин
- Хүнсний аюулгүй байдлын үндсэн зарчим
- Орон нутгийн тандалтын чиглэл

Семинар — 4 академик цаг

- Агаар, ус, хог хаягдлын эрсдэлийн кейс

- ХАБЭА–гийн эрсдэлийн матриц ашиглах
- Хүнсний хордлогын бүлгийн дэгдэлтийн жишээ
- Олон нийтийн дарамт, сэтгэлзүй, мэдээлэл өгөх тактик

Дадлага — 4 академик цаг

- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх дадлага
- Хүнсний аюулгүй байдлын хяналтын чеклист ашиглах
- Орчны эрүүл мэндийн тандалтын богино маршрутын дадлага
- Хордлогын үед анхны арга хэмжээ авах симуляци

Бие даалт — 2 академик цаг

- Орон нутгийн нэг эрсдэлийг сонгон шинжилгээ хийх (ус, агаар, хүнс)
- Хяналтын тайлан бэлтгэх

Үнэлгээ — 1 академик цаг

- Эрсдэлийн матриц бөглөх
- Хүнсний эрсдэлийн жишээгээр богино дүн шинжилгээ
- ХАБЭА–гийн нэг кейсийн шийдэл

Модуль 12 Эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, технологийн хүртээмж ба зохистой хэрэглээ

Модулийн зорилго

Энэхүү модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад эм, вакцин, эмнэлгийн хэрэгсэл, оношилгооны технологийн хүртээмжийг хангах, аюулгүй, үр дүнтэй, нотолгоонд суурилсан хэрэглээг төлөвшүүлэх, нөөцийн зохистой менежмент хийх чадвар эзэмшүүлэхэд оршино. Мөн эмийн зохистой хэрэглээ, хангамжийн сүлжээ, сэрэмжлүүлэг ба тайлагнал, хуурамч эмийн эрсдэл, эмийн гаж нөлөөг мэдээлэх үйл ажиллагааг сайжруулахыг зорьдог.

Модуль нь EPHF-12 (Эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, технологийн хүртээмж), EPHF-5 (Эрүүл мэндийг хамгаалах), EPHF-10 (Үйлчилгээний чанар, тэгш байдал) чиг үүргүүдтэй уялдана.

Үндсэн агуулга

Эмийн зохистой хэрэглээний үндэс

- Эмийн зохистой хэрэглээ гэж юу вэ?

- Нотолгоонд суурилсан клиник шийдвэр
- Эмийн бүлгүүд, үйлдлийн механизм
- Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээ (Antimicrobial stewardship – AMS)
- Эмийн гаж нөлөө (ADR) илрүүлэх, мэдээлэх

Вакцин, дархлаажуулалтын менежмент

- Вакцины төрөл, үйлчлэлийн зарчим
- Хүйтэн хэлхээ (Cold chain) – температурын хяналт
- Вакцины чанарын алдагдлын эрсдэл (VVM, exposure events)
- Дархлаажуулалтын бүртгэл, тайлан
- Дархлаажуулалтын дутуу хамрагдалтын эрсдэлийн үнэлгээ
- Вакцины дараах сөрөг үйлдлийг илрүүлэх, мэдээлэх (AEFI)

Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт

- Үндсэн төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагаа
- Ариутгал, халдвар хяналтын зарчим
- Хэрэгслийн элэгдэл, ашиглалтын бүртгэл
- Оношилгооны түргэвчилсэн тестийн зөв хэрэглээ

Нөөцийн менежмент, хангамжийн сүлжээ

- Эрүүл мэндийн байгууллагын хангамжийн үндсэн үйл явц
- Нөөц тооцох арга (average monthly consumption, buffer stock)
- Захиалга төлөвлөх (LMIS ашиглалт)
- Дуусалт, алдагдлын эрсдэлийн үнэлгээ
- Хууль бус, хуурамч эмээс хамгаалах зарчим

Шуурхай мэдээлэл, тайлагнал

- Эмийн гаж нөлөө мэдээлэх (Pharmacovigilance)
- AEFI мэдээлэх сувгууд
- Вакцины чанар алдагдах үед авах арга хэмжээ
- Эмийн хомсдолын үеийн шуурхай удирдлага

Суралцахуйн үр дүн

- Эмийн зохистой хэрэглээний үндсэн зарчим, антибиотик зохистой хэрэглээний ач холбогдлыг тайлбарлана.
- Вакцин, эмнэлгийн хэрэгсэл, технологийн аюулгүй менежментийн үндсийг мэднэ.
- Эм, вакцины нөөц тооцох, тайлагнах үндсэн зарчмуудыг ойлгоно.
- Эмийн зохистой хэрэглээг практикт хэрэгжүүлэх.

- Вакцины хүйтэн хэлхээг хянах, гаж нөлөөг мэдээлэх.
- Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аюулгүй ашиглах.
- Орон нутгийн хангамжийн системээр нөөц тооцож, захиалга төлөвлөх.
- Эмийн гаж нөлөө, AEFI, чанарын доголдлыг таньж шуурхай мэдээлэх.
- Эмийн аюулгүй байдал, өвчтөний эрхийг дээдлэх хандлага төлөвших.
- Технологийг хариуцлагатай, нотолгоонд тулгуурлан ашиглах.
- Хангамжийн ил тод, хариуцлагатай соёлыг дэмжих.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 6 академик цаг

- Эмийн зохистой хэрэглээ
- AMS үндсэн зарчим
- Вакцины менежмент
- Хангамжийн сүлжээ

Семинар — 4 академик цаг

- Эмийн гаж нөлөөний жишээ задлан шинжлэх
- Вакцины хүйтэн хэлхээ тасалдах кейс
- Нөөцийн тооцоо хийж дадлагажих
- Оношилгооны тестийн чанарын хяналт

Дадлага — 4 академик цаг

- Хүйтэн хэлхээний төхөөрөмжийн температур шалгах
- Эмийн захиалга хийх симуляци
- Эмийн өрөөний зохион байгуулалт үнэлэх

Бие даалт — 2 академик цаг

- Байгууллагын эм-вакцины нөөцийн үнэлгээ хийх
- AEFI эсвэл ADR тохиолдлын тайлан бэлтгэх

Үнэлгээ — 1 академик цаг

- Эмийн зохистой хэрэглээний кейс
- Хүйтэн хэлхээний асуудлын шийдэл
- Нөөцийн тооцоо
- AEFI/ADR таних богино дасгал

11 дүгээр долоо хоног: Модуль 11 Судалгаа, нотолгоо, мэдлэгийн удирдлага

Модулийн зорилго

Энэ модулийн зорилго нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр

гаргалт, мэдээллийг цуглуулах–дүгнэх–хуваалцах арга зүйг эзэмшүүлэх, байгууллагын түвшинд мэдлэгийн удирдлага (knowledge management) хэрэгжүүлэх чадвар төлөвшүүлэхэд оршино. Мөн орон нутгийн түвшинд бичил судалгаа хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, бодлого боловсруулагчдад ойлгомжтойгоор танилцуулах чадварыг хөгжүүлнэ.

Модуль нь EPHF-11 (Судалгаа, нотолгоо, мэдлэгийн удирдлага), EPHF-1 (Тандалт ба өгөгдөл), EPHF-10 (Үйлчилгээний чанар), EPHF-7 (Эрүүл мэндийг дэмжих) чиг үүргүүдтэй уялдана.

Үндсэн агуулга

Нийгмийн эрүүл мэндийн судалгааны суурь ойлголт

- НЭМ судалгааны зорилго, ач холбогдол
- Судалгааны үндсэн төрлүүд:
 - Тоон (quantitative)
 - Чанарын (qualitative)
 - Холимог (mixed methods)
- Анхан шатны байгууллагад тохирох судалгааны чиглэлүүд (ХӨС, ХБӨ, зан үйл, орчны эрүүл мэнд, эмийн хэрэглээ, үйлчилгээний чанар)

Судалгааны үндсэн үе шат

- Асуудал тодорхойлох арга ("Root-cause" үнэлгээ, Fishbone, 5 Why's)
- Судалгааны асуулт томъёолох
- Хэмжүүр ба үзүүлэлт сонгох
- Түүвэр авах суурь ойлголт
- Асуумаж, ярилцлагын удирдамж боловсруулах зарчим
- Ёс зүй ба зөвшөөрөл (ethical clearance, informed consent)

Өгөгдөл цуглуулах ба чанарын хяналт

- Бүртгэл–тайлан ашиглан өгөгдөл цуглуулах
- Чанарын шалгуур (accuracy, consistency, completeness)
- Чанарын хяналтын матриц

Өгөгдлийн дүн шинжилгээ

- Тоон өгөгдлийн үндсэн шинжилгээ: хувиар, дундаж, тархалт

- Чанарын өгөгдөл боловсруулах: кодлох, сэдэв гаргах (thematic analysis)
- Excel болон энгийн програм ашиглах

Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт

- Нотолгоо гэж юу вэ?
- Нотолгоог үнэлэх 5 түвшин
- НЭМ үйл ажиллагааны циклд нотолгоо ашиглах
- Evidence-to-action загвар

Мэдлэгийн удирдлага (Knowledge management)

- Байгууллагын мэдлэгийн капитал
- Мэдлэг цуглуулах, хадгалах, ашиглах, түгээх
- Кейс түвшний сургамж (lessons learned)
- Мэдлэгийн сан (KM repository) байгуулах үндэс
- Тасралтгүй сайжруулалтын "Plan-Do-Check-Act" мөчлөг

Тайлагнах болон үр дүн танилцуулах

- Богино мэдээллийн хураангуй (policy brief)
- Шийдвэр гаргагчдад зориулсан 1 хуудас тайлан
- Судалгааны үр дүнг олон нийтэд ойлгомжтой тайлбарлах
- Шинэ CDC байгууллагын суурь зарчимтай нийцсэн мэдээлэл солилцоо

Суралцахуйн үр дүн

- НЭМ судалгааны үндсэн ойлголт, төрлүүд, үе шатыг тайлбарлана.
- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын ач холбогдол, түвшинг мэднэ.
- Мэдлэгийн удирдлагын зарчим, байгууллагын сургамжийг хадгалах аргачлалыг ойлгоно.
- Судалгааны асуулт боловсруулах, асуумж/ярилцлага боловсруулах.
- Энгийн өгөгдөл цуглуулах, кодлох, дүн шинжилгээ хийх.
- Нотолгоонд суурилсан тайлан бэлтгэх.
- Бодлогын тойм, нэг нүүр хураангуй боловсруулах.

- Байгууллагын түвшинд мэдлэг түгээх (KM) механизмыг хэрэгжүүлэх.
- Ёс зүйг баримтлах, мэдээллийг хариуцлагатай ашиглах.
- Нотолгоонд тулгуурлан ажиллах системтэй хандлага төлөвших.
- Байгууллагын хамтын суралцах соёлыг дэмжих.

Хичээлийн зохион байгуулалт

Лекц — 6 академик цаг

- Судалгааны үндсэн ойлголт
- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт
- Мэдлэгийн удирдлагын мөчлөг
- Судалгааны ёс зүй

Семинар — 4 академик цаг

- Судалгааны асуулт боловсруулах
- Асуумаж боловсруулах дасгал
- Өгөгдлийн чанарын хяналтын кейс

Дадлага — 4 академик цаг

- Excel ашиглан өгөгдөл кодлох, дүн шинжилгээ хийх
- Чанарын өгөгдлийн энгийн кодчлол
- One-page summary бэлтгэх
- Асуудлын үнэлгээ (5 Why's / Fishbone) хийх

Бие даалт — 2 академик цаг

- Орон нутгийн түвшний жижиг судалгааны санал боловсруулах
- 1 хуудас тайлангийн загвар бэлтгэх

Үнэлгээ — 1 академик цаг

Явцын үнэлгээ №4

- Судалгааны асуулт боловсруулах
- Нотолгоонд үндэслэсэн богино тайлан
- Дүн шинжилгээний үр дүнг тайлбарлах

12 дугаар долоо хоног: Портфолио, тайлан хамгаалалт /төгсгөлийн шалгалт/

Зорилго

Суралцагчийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний тогтолцоо, мэргэжлийн болон мэргэжил–арга зүйн байгууллагуудын чиг үүрэг, оролцогч талуудын хамтын ажиллагааны экосистемтэй танилцуулж, мэргэжлийн практикт хэрэгжүүлэх чадамжуудыг бататгах. Мөн сургалтын явцад гүйцэтгэсэн даалгавар, портфолиоог үнэлж, төгсөгчийн чадамжийн түвшинг эцэслэн баталгаажуулах.

Үндсэн агуулга

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний байгууллагуудтай танилцах

- Суралцагчид дараах байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаа, хамтын ажиллагааны боломжуудтай танилцана:
 - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ)
 - Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)
 - Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ) – One Health хандлага
 - Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори / МХЕГ
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв (ХАБЭМТ)
 - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
 - Аймаг/дүүргийн НЭМГ, НЭМТ-ийн үйл ажиллагааны жишээ

Танилцах аяллын зорилго:

- НЭМ-ийн бодлого боловсруулах, мэргэжил–арга зүйн удирдлага, тандалт–хариу арга хэмжээ, лаборатори, судалгаа, эрсдэлийн харилцааны үйл ажиллагааг газар дээр нь ажиглах
- Суралцагчдын байгууллага хоорондын хамтын ажиллагааны ойлголтыг гүнзгийрүүлэх
- НЭМ-ийн чиг үүргийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах

Воркшоп — Чадамж бататгах дадлага

Суралцагчид 2–3 баг болж, бодит нөхцөлд тулгуурласан интеграцчилсан кейс дээр ажиллана.

Кейсийн чиглэлүүдийн жишээ:

- Хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар EPHF-ийн олон чиг үүрэг уялдуулсан шийдэл боловсруулах
- “Салбар хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөө” гаргах
- “Эрсдэлийн үнэлгээ + Хариу арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах
- Эмнэлгийн болон орчны эрүүл мэндийн өгөгдөлд тулгуурласан шинжилгээ–шийдвэрийн тайлан гаргах

- НЭМ-ийн үйл ажиллагааны нэг чиглэлээр богино public health campaign бүтээх (RCCE)

Воркшопын бүтээгдэхүүн:

- 1 хуудас бодлогын хураангуй
- Шийдвэрийн мод (decision tree)
- Stakeholder mapping
- Эрт сэрэмжлүүлэх шуурхай тайлан
- НЭМ үйл ажиллагааны төлөвлөгөө (mini action plan)

Төгсгөлийн үнэлгээ

Суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлага гурвыг үнэлнэ.

1) Онолын шалгалт

- 40–50 асуулт (сонгох, нөхөх, богино хариулт)
- Цөм агуулга 1–12 бүх сэдвийг хамарсан
- Шалгуур босго: $\geq 70\%$

2) Практик шалгалт (OSPE төстэй хэлбэр)

3–4 өртөөгөөр:

- Тандалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Эрсдэлийн үнэлгээний матриц бөглөх
- Хүйтэн хэлхээний алдааг илрүүлэх
- Community engagement зардлын тооцоо/ төлөвлөлт

3) Портфолио үнэлгээ

Суралцагч доорх ажлыг хөтөлбөрийн туршид цуглуулж бүрдүүлсэн байна:

- Бие даалтууд (индикатор тооцоо, кейс дүн шинжилгээ)
- 1 хуудас эсвэл Policy brief
- EWARS дохио тайлагнасны кейс
- Stakeholder mapping
- Joint Action Plan
- Судалгааны асуулт + мини-судалгааны санал
- ХАБЭА үнэлгээний чеклист
- Хүнсний эрсдэлийн үнэлгээ
- Хөтөлбөрийн туршид хийсэн бүх даалгаврын нэгтгэл

Портфолио үнэлгээний шалгуур:

- Чанар
- Нотолгоонд суурилсан байдал
- Бүрэн байдал

- Интеграцчилсан сэтгэх чадвар
- Бодит ажлын байранд хэрэгжүүлэх боломж

НАЙМ. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

Энэхүү 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтын үнэлгээ нь чадамжид суурилсан үнэлгээний зарчмыг баримталж, суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлагын ахиц дэвшлийг тасралтгүй хянах болон сургалтын төгсгөлд эзэмшсэн чадамжийг баталгаажуулах хоёр хэсгээс бүрдэнэ. Үнэлгээний зорилго нь суралцагчийн бодит ажлын байран дахь гүйцэтгэл болон EPHF-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цогц чадамжийг хангалттай түвшинд эзэмшсэн эсэхийг тодорхойлох юм.

1. Явцын үнэлгээ (Formative assessment)

Сургалтын нийт үнэлгээний 50%

Явцын үнэлгээ нь долоо хоног бүрийн сургалтын агуулгад нийцсэн даалгавар, кейс судалгаа, семинарын оролцоо, дадлагын гүйцэтгэлээр дамжуулан суралцагчдын ахиц дэвшлийг тогтмол үнэлнэ.

Явцын үнэлгээний бүрэлдэхүүн:

- 1.1. Долоо хоногийн даалгавар, кейс судалгаа (20%)
- 1.2. Семинарын идэвх, багийн ажил (10%)
- 1.3. Дадлагын гүйцэтгэл (15%)
- 1.4. Явцын богино шалгалтууд – 4 удаа (5%)

2. Төгсгөлийн үнэлгээ (Summative assessment)

Сургалтын нийт үнэлгээний 50%

Сургалтын төгсгөлд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагын цогц байдлыг нэгдсэн байдлаар үнэлж, чадамжийн түвшнийг баталгаажуулна.

- 2.1. Эцсийн онолын шалгалт – 20%

40–50 даалгавар

Сонгох, нөхөх, богино хариулт

Цөм агуулга 1–11 бүх модулийг хамарсан

Шалгуур босго: **≥70%**

- 2.2. Практик шалгалт (OSPE хэлбэр) – 15%

3–4 өртөөгөөр гүйцэтгэнэ:

- Тандалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Эрсдэлийн үнэлгээний матриц бөглөх
- Хүйтэн хэлхээний доголдлыг илрүүлэх
- Оношилгооны түргэвчилсэн тест ашиглах

Өртөө бүрд чадамжийн шалгуурт тулгуурласан үнэлгээ хийнэ.

2.3. Портфолио үнэлгээ – 10%

Суралцагч сургалтын туршид дараах ажлыг багцлан бүрдүүлнэ:

- Бие даалтын ажлууд
- Шийдвэрлэж, тайлагнасан тохиолдлууд
- Оролцогч талуудын шинжилгээ
- Богино бодлогын хураангуй
- Хүнсний, орчны, ХАБЭА үнэлгээний чеклист
- НЭМ үйл ажиллагааны жижиг төлөвлөгөө

Портфолио үнэлгээний шалгуур:

- Бүрэн байдал
- Чанар ба үнэн зөв байдал
- Нотолгоонд суурилсан дүгнэлт
- Шинжилгээний гүнзгийн байдал
- Ажлын байран дээр хэрэгжүүлэх боломж

2.4. Воркшопын интеграцчилсан төслийн ажил – 5%

12 дахь долоо хоногт зохион байгуулна.

Баг бүр дараах ажлуудын аль нэгийг гүйцэтгэнэ:

- Эрсдэлийн үнэлгээ + хариу арга хэмжээний төлөвлөгөө
- Хамтын ажиллагааны төлөвлөгөө (Joint Action Plan)
- НЭМ-ийн бодит асуудлаар нэг хуудас тайлан
- Өгөгдөлд суурилсан шийдвэрийн дүн шинжилгээ

3. Үнэлгээний дүн гаргалт

Суралцагч дараах шалгуурыг хангасан үед төгссөнд тооцно:

1. Явцын үнэлгээ $\geq 70\%$
2. Төгсгөлийн үнэлгээ $\geq 70\%$
3. Үүнд, эцсийн онолын шалгалт $\geq 70\%$ босго давсан байх
4. Портфолио шаардлагын дагуу бүрэн багцлагдсан байх

4. Үнэлгээний зарчим

- Чадамжид суурилсан, үнэлгээний олон аргыг хослуулсан
- Ил тод, ойлгомжтой шалгууртай байх
- Бодит ажлын байрны нөхцөлтэй уялдсан
- Суралцахуйн ахиц дэвшлийг дэмжсэн, зааварчилгаатай
- Суралцагчийн хариуцлага, оролцоог дэмжсэн

ЕС. НОМ ЗҮЙ

Энэхүү хөтөлбөрийн сургалт, дадлага, үнэлгээг хэрэгжүүлэхэд дараах үндсэн бүлгийн материалуудыг ашиглана.

I. Монгол Улсын хууль, бодлого, стандарт

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн бодлого, тандалт-хяналт, орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр мөрдөгдөж буй үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, журам, удирдамжууд.

II. Үндэсний журам, заавар, мэргэжлийн удирдамж

Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, стандарт, аргачлал, заавар, үйл ажиллагааны удирдамж.

III. Олон улсын баримт бичиг, стандарт, аргачлал

Эрүүл мэндийн үндсэн чиг үүрэг, тандалт, хариу арга хэмжээ, эрүүл мэндийг дэмжих, бодлого боловсруулах, салбар хоорондын зохицуулалтын чиглэлээрх олон улсын нбайгууллагаас гаргасан удирдамж, дүрэм, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн.

IV. Судалгааны ном, сэтгүүл, шинжлэх ухааны эх сурвалц

Нотолгоонд суурилсан бодлого, эрүүл мэндийн системийн үнэлгээ, зан үйлийн өөрчлөлт, эрүүл мэндийн эдийн засаг, эпидемиологи, орчны эрүүл мэнд, эрсдэлийн удирдлагын чиглэлээр ашиглах үндсэн ном, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүллүүд.

V. Сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагажих материал

Сургалтын явцад ашиглах практик материал, кейс судалгаа, дасгалын багц, симуляцийн хөтөлбөр, багшийн гарын авлага, цахим сургалтын платформ.

VI. Мэдээллийн систем, өгөгдлийн сан

Сургалтын практикт ашиглах бодит өгөгдөл, мэдээллийн системүүд.

VII. Багшийн гарын авлага, үнэлгээний хэрэгсэл